

2024 оны 4 сар 28 өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

***Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Инновэйшн Инвестмент” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн дагуу энэхүү тогтоолын Хавсралт№1-т заасны дагуу Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг, Хавсралт№2-т заасны дагуу Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт тус тус Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Д.ДАВАА /

2024 оны 4 сар 28 өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.9 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Инновэйшн инвестмент” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 551 тоот тогтоолоор үнэт цаасаа бүртгүүлж, хувьцаагаа нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн болохыг дурдсугай.
2. Үүнтэй холбогдуулан, компанийн хэлбэрийг “Инновэйшн инвестмент” ХК болгон өөрчлөхөөр шийдвэрлэсүгэй.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн дүрмийг Хавсралт №1-ийн дагуу шинэчлэн баталсугай.
4. Компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, баримт бичиг хүргэх, хүлээн авах эрхийг С.Гүржав /РД: ТБ81112013/-д итгэмжлэн олгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Д.ДАВАА /

2024 оны 4 сар 28 өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлж,
шинээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилох тухай*

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 62.1.16 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсугай:
 - Б.Анхболд /██████████/-г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - А.Баттамир /██████████/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - Б.Чулуунсүх /██████████/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - Г.Хатанболд /██████████/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - У.Мөнхзул /██████████/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - У.Наранбаатар /██████████/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - Т.Дашцэрэн /██████████/-г -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
 - Ш.Уянга /██████████/-г -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
 - Д.Ганзориг /██████████/-г -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж болон улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.
- Төлөөлөн удирдах зөвлөл томилогдсонтой холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаа сонгох, компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд зохистойгоор удирдан явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГАС



/Д.ДАВАА /